

Сурах хугацаанд ажил ба мэргэжлийн чиг баримжаа авах болон санхүүгийн дэмжлэг авах

Trygghetsfonden TSL нь хөдөлмөрийн зах зээл дэх ирээдүйн байр сууриа бэхжүүлэхийн тулд үр чадвараа хөгжүүлэхэд тань туслана. Дэмжлэгт ажил ба мэргэжлийн чиг баримжаа авах, мөн хэрэв сурах бол санхүүгийн дэмжлэг авах боломж багтана.

Дэмжлэгийн тусламжтайгаар та одоогийн үүрэг доторх мэдлэгээ гүнзгийрүүлж, үр чадвараа өргөжүүлэх, мэргэжлээ бүхэлд нь эсвэл хэсэгчлэн өөрчлөх боломжтой. Энэ нь танд хөдөлмөрийн зах зээлд эрэлт хэрэгцээтэй, өрсөлдөх чадвартай байх боломж олгоно.

Дэмжлэг нь ажлын байранд тань хамаарах хамтын гэрээний нэг хэсэг бөгөөд танд үнэ төлбөргүй.

Энэ нь дараах байдалтай байна:

1. Өргөдөл

Та TSL.se сайтад зочилж, дэмжлэгийн талаар дэлгэрэнгүй уншиж, чиг баримжаа авах хүсэлтээ гаргаж болно.

2. Холбоо тогтоох

Өргөдөл гаргасны тань дараа бид тантай холбоо барьж, таны нөхцөл байдал, боломжийн талаар ярилцаж, анхны чиг баримжаа олгоно.

3. Чиг баримжаа олгох

Та өөрөө хүсэж байгаа, мөн танд шаардлагатай бол бид дахин үүлзалт хийж, ажил ба мэргэжлийн гүнзгийрүүлсэн чиг баримжаа олгоно.

4. Богино эсвэл урт хугацааны сургалт

- Хэрэв та таваас доош хоногийн сургалтанд хамрагдах бол Trygghetsfonden TSL-ээс санхүүгийн дэмжлэг авах эрхтэй байж болно. Хэрэв бид санхүүгийн дэмжлэгийг зөвшөөрвөл та сургалтанд хамрагдсаныхаа дараагийн сард мөнгөө авна.
- Хэрэв та тав эсвэл түүнээс дээш хоногийн хугацаатай сургалтанд хамрагдах бол та CSN-ээс шинэ мэргэжил эзэмших сургалтын дэмжлэг болон Trygghetsfonden TSL-ээс нэмэлт санхүүгийн дэмжлэг авах эрхтэй байж болно. Бид танд CSN-ы өргөдөл гаргахад тань туслах боломжтой. Дэмжлэг зөвшөөрөгдвөл та сургалт эхлэх үед мөнгөө авч эхэлнэ.

Ажил ба мэргэжлийн баримжаа авах болзлууд:

- Та Svenskt Näringsliv болон LO-ийн гэрээний хүрээнд хамтын гэрээ байгуулсан компанид ажилладаг.
- Та сүүлийн 24 сарын дор хаяж 12-т нь ажилласан.
- Та 65 нас хүрээгүй.

Санхүүгийн дэмжлэг авах үндсэн болзлууд:

- Та сүүлийн 24 сарын дор хаяж 12-т нь ажилласан.
- Та сүүлийн 14 жилийн дор хаяж 8-д нь ажилласан.
- Та 27-62 настай.

Үүнээс гадна нэмэлт болзол хамаатай тул тэр талаар бидэнтэй холбоо барина уу. Санхүүгийн дэмжлэг нь сурах хугацаанд тань ердийн орлогын тань 80 хүртэлх хувийг нөхөн төлнө. Та бүтэн цагаар сурах бол дээд тал нь 44 долоо хоног (эсвэл 60 нас хүрснээс хойш 10 долоо хоног) санхүүгийн дэмжлэг авах боломжтой бөгөөд хагас цагаар сурах бол үүнээс дээш хугацаагаар авах боломжтой.

Дэлгэрэнгүй мэдээлэл ба ганцаарчилсан тусламж

Дэмжлэгийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл манай TSL.se вэбсайт дээр бий. Сайтын дээд талд хэлээ өөрчлөх боломжтой хэрэгсэл бий.

Ганцаарчилсан тусламж авахын тулд бидэнтэй холбоо барина уу:

- Утсаар: 010-480 91 20
- Цахим шуудангаар: info@tsl.se